

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2007 оны 11 дүгээр
сарын 29-ны өдөр

Дугаар 179

Улаанбаатар
хот

Дүрэм шинэчлэн батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2 дахь заалтыг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1."Санхүүгийн зохицуулах хорооны улсын байцаагчийн дүрэм"-ийг хавсралтаар баталсугай.

2.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Үнэт цаасны хорооны 2003 оны 14 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт, Санхүүгийн зохицуулах хорооны 2006 оны 24 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба /О.Ганбат/-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ УЛСЫН БАЙЦААГЧИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл.

1.1. Энэхүү дүрмийн зорилго нь Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-ны улсын байцаагч /цаашид “улсын байцаагч” гэх/-ийн бүрэн эрх, баталгаа, үйл ажиллагааны чиглэл, хүлээх үүрэг, хариуцлага болон санхүүгийн зах зээлийн зохицуулалтад холбогдох хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлэн Хорооноос гаргасан дүрэм, журмыг зөрчигчид захиргааны шийтгэл ногдуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Улсын байцаагч, түүний бүрэн эрхийн хугацаа, эрх олгох, түтгэлзүүлэх, хүчингүй болгох

2.1. Хороо нь улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагчтай байна.

2.2. Хорооны дарга улсын ерөнхий байцаагч байна.

2.3. Хорооны гишүүд улсын ахлах байцаагчийн эрхтэй байх бөгөөд түүнийг нь улсын ерөнхий байцаагч олгоно.

2.4. Улсын ерөнхий байцаагч дараах шаардлагыг хангасан Ажлын албаны холбогдох албан тушаалтан, ажилтанд улсын ахлах байцаагчийн болон улсын байцаагчийн эрхийг олгоно:

2.4.1. Төрийн захиргааны албан хаагчийн шалгалт өгч, тангараг өргөсөн;

2.4.2. Хорооны ажлын албанд нэгээс доошгүй жил ажилласан;

2.4.3. Тухайн салбарын ажлын мэдлэг чадвар эзэмшсэн, үүрэгт ажлын чиглэлээр мэргэшиж, хяналт шалгалтын ажлын зохих дадлага, туршлага хуримтлуулсан;

2.4.4. Сахилгын шийтгэлгүй.

2.5. Улсын байцаагч нь үнэмлэх, дугаар бүхий тэмдэгтэй байж, албан шаардлага, зөрчлийн тухай тэмдэглэл, шийтгэвэрийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

2.6. Улсын байцаагчийн бүрэн эрхийн хугацаа нь тухайн албан тушаалыг хаших хугацаанд хадгалагдана.

2.7. Улсын байцаагч нь чиг үүргээ хэрэгжүүлэхдээ Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Хорооны ажилтны ёс зүйн дүрэм болон энэ дүрмийг мөрдлөгө болгон ажиллана.

2.8. Хорооны Ажлын албанаас улсын байцаагчийн түвшин тогтоох шалгалтыг 2 жилд нэг удаа зохион байгуулна.

2.9. Улсын ерөнхий байцаагч дараах үндэслэлээр улсын байцаагчийн эрхийг түтгэлзүүлэх шийдвэр гаргана:

2.9.1. Хуулийн байгууллагаас шалгагдаж байгаатай нь холбогдуулан хүсэлт ирүүлсэн;

2.9.2. Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу түр чөлөөлөгдсөн;

2.9.3. Улсын байцаагчийн түвшин тогтоох шалгалтад тэнцээгүй.

2.10. Улсын ерөнхий байцаагч нь дараах үндэслэлээр улсын байцаагчийн эрхийг хүчингүй болгох шийдвэр гаргана:

2.10.1. Төрийн албаны тухай хууль, Хорооны ажилтны ёс зүйн дүрэм, энэ дүрмийн 4-д заасан эрх үүргээ биелүүлээгүй, 6-д заасан үйл ажиллагааг хэрэгжүүлсэн нь тус тус нотлогдсон;

2.10.2. Хяналт шалгалтын бус чиг үүргийг хэрэгжүүлэх ажил, албан тушаалд томилогдсон;

2.10.3. Улсын байцаагчийн түвшин тогтоох шалгалтад 2 буюу түүнээс дээш удаа тэнцээгүй.

Гурав. Улсын байцаагчийн үйл ажиллагааны чиглэл, зарчим

3.1. Улсын байцаагч хууль тогтоомжоор олгогдсон эрх үүргээ хэрэгжүүлэхдээ Төрийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлд зааснаас гадна дараах зарчмуудыг удирдлага болгон ажиллана:

- хууль дээдлэх;

-шудрага ёсыг эрхэмлэх;

-бусдын нөлөөнд үл автах;

-шалгуулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол, нэр төрийг хүндэтгэх;

-асуудалд бодитой хандаж, шалгалтыг гагцхүү үндсэн баримтад тулгуурлан хийх.

3.2. Улсын байцаагч хяналт шалгалтын үйл ажиллагааг дараах чиглэлээр хэрэгжүүлнэ:

3.2.1. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хоршооны тухай хууль, Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Компанийн тухай хууль, Захиргааны хариуцлагын тухай хууль болон бусад хууль, тэдгээрт нийцүүлэн гаргасан Улсын Их Хурал, Засгийн Газрын шийдвэр, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан дүрэм, журам, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих;

3.2.2. Санхүүгийн зах зээлд оролцогч байгууллагуудын бүхий л үйл ажиллагаа хууль, тогтоомжид нийцэж байгаа эсэхэд хяналт тавьж, шалгалт хийх, илэрсэн зөрчлийн шалтгаан нөхцөлийг тогтоох, захиргааны шийтгэл ногдуулах, хэрэгжилтийг хангуулах;

3.2.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигчид хооронд болон тусгай зөвшөөрөл эзэмшигч, үйлчлүүлэгчийн хооронд үүссэн маргааныг Хороонд ирүүлсэн албан бичиг, өргөдөл, гомдлыг үндэслэн шалгаж шийдвэрлэх;

Дөрөв. Улсын байцаагчийн эрх, үүрэг, түүнийг хэрэгжүүлэх баталгаа

4.1. Улсын байцаагч дараах эрхтэй:

4.1.1. Хяналт шалгалт хийх объектод саадгүй нэвтрэн орох, хяналт шалгалтын ажилд шаардлагатай гэж үзсэн бүхий л баримтыг шалгуулагчаас болон холбогдох байгууллага, албан тушаалтан, иргэнээс үнэ төлбөргүй гаргуулан авах, гаргаж өгөхийг шаардах;

4.1.2. Хяналт шалгалтын ажилд саад учруулсан, эсэргүүцсэн, доромжилсон этгээдэд өөрийн эрх хэмжээний хүрээнд болон эрх бүхий байгууллагад мэдэгдэж, зохих арга хэмжээ авах;

4.1.3. Зөрчил, дутагдал гаргасан нь нотлогдсон тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд захиргааны шийтгэл ногдуулах, түүнийг арилгуулахаар албан шаардлага өгөх, гүйцэтгэлийг хангуулах, үйл ажиллагааг нь бүхэлд нь буюу хэсэгчлэн түр зогсоох;

4.1.4. Хууль тогтоомжийг ноцтой буюу удаа дараа зөрчсөн тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох саналыг Хорооны хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэх;

4.1.5. Хяналт шалгалтын ажлын зорилтыг хангахын тулд Хорооны дүрмийн 2.2.5-т заасныг үндэслэн шаардлагатай асуудлыг магадлах, тодорхой асуудлаар мэргэжил, мэргэшлийн дэмжлэг авах, дүгнэлт гаргуулах зорилгоор хяналт шалгалтын ажилд бусад холбогдох байгууллагын мэргэжилтнийг татан оролцуулах саналыг харьяалагдах газрын улсын ахлах байцаагчид тавьж шийдвэрлүүлэх;

4.1.6. Шалгалтад хамрагдсан, зөрчил гаргасан этгээдийн хувь нийлүүлэгч, үйлчлүүлэгчдэд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, хууль бусаар олсон орлогыг улсын орлого болгох арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх;

4.1.7. Өөрийн хяналт, шалгалт хийсэн ажилтай холбогдох хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд оролцох, тайлбар өгөх.

4.2. Улсын байцаагч дараах үүргийг хүлээнэ:

4.2.1. Санхүүгийн зах зээлийг зохицуулж буй хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан дүрэм, журам, зааврын биелэлтэд хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах;

4.2.2. Хяналт шалгалтыг удирдамж болон томилолтод заасан хугацаанд бүрэн гүйцэд хийх, шалгалтын удирдамжийг шалгуулах байгууллагад танилцуулах;

4.2.3. Өөрөө үйлчлүүлдэг зохицуулалтын хүрээний санхүүгийн байгууллага, мэргэжлийн оролцогчдыг шалгах аас татгалзах;

4.2.4. Санхүүгийн зах зээлд оролцогч байгууллагууд нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангаа зохих журмаар тогтоосон хугацаанд нь Хороонд ирүүлж, шаардлагатай этгээдүүдэд хүргэж байгаа эсэх болон тайлан балансад тусгасан мэдээний үнэн зөв эсэхийг магадлан шалгаж, хяналт тавих;

4.2.5. Шийтгэврийн хуудасны тооцоог Хорооны Эрх зүйн хэлтэстэй тухай бүр 10 хоногийн дотор хийж, хугацаанд нь барагдуулах талаар хяналт тавьж ажиллах;

4.2.6. Хяналт шалгалтын тайлан, дүгнэлт, танилцуулга, өгсөн албан шаардлага, бичсэн зөрчлийн тухай тэмдэглэл, шийтгэврийн хуудасны хууль зүйн үндэслэл, нотолгоо, тэдгээрт орсон тоо, баримтын үнэн зөвийг гагцхүү өөрөө хариуцах;

4.2.7. Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил нь гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг агуулсан гэх үндэслэлтэй бол шалгалтын тайлан, дүгнэлт, холбогдох баримтыг харьяалагдах газрын улсын ахлах байцаагчид танилцуулах;

4.3. Улсын байцаагч дээр дурдсан эрх, үүрэг хүлээхээс гадна Төрийн албаны тухай хуулийн 13, 14, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 25, Төрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан нийтлэг эрх, үүргийг мөн хүлээнэ.

4.4. Улсын ахлах байцаагч нь энэ дүрмийн 4.1, 4.2, 4.3-д зааснаас гадна дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

4.4.1. Улсын байцаагчаас тавьсан албан шаардлага, зөрчлийн тухай тэмдэглэл, ногдуулсан захиргааны шийтгэл нь холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн гэж үзвэл тэдгээрийг засаж залруулах, хүчингүй болгох;

4.4.2. Зөрчил гаргасан гэж үзсэн улсын байцаагчийн эрхийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох саналыг улсын ерөнхий байцаагчид тавьж шийдвэрлүүлэх;

4.4.3. Иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, бусад мэдээ, мэдээллийн мөрөөр тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагын үйл ажиллагааг шалгуулахаар улсын байцаагчийг томилон ажиллуулах;

4.4.4. Улсын байцаагчийн хяналт шалгалтын үйл ажиллагаа, түүний гүйцэтгэлд хяналт тавих;

4.4.5. Улсын байцаагчийг мэргэжил, арга зүйн удирлагаар хангах, мэргэшлийг нь дээшлүүлэх арга хэмжээ авах асуудлыг Хорооны улсын ерөнхий байцаагчид тавьж шийдвэрлүүлэх;

4.4.6. Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил нь гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг агуулсан гэх үндэслэлтэй бол шалгалтын тайлан, дүгнэлт, холбогдох баримтыг улсын ерөнхий байцаагчид танилцуулах;

4.4.7. Улсын байцаагч нараас тавьсан албан шаардлага, үйлдсэн зөрчлийн тухай тэмдэглэл, шийтгэврийн хуудасны талаарх тоо мэдээ, эх хувьтай танилцах.

4.5. Улсын ерөнхий байцаагч энэ дүрмийн 4.1, 4.2, 4.3, 4.4-д зааснаас гадна дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

4.5.1. Улсын байцаагчийн эрх олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох тухай шийдвэр гаргах;

4.5.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч, хуулийн этгээдүүдийн үйл ажиллагаанд хийх хяналт шалгалтын удирдамж батлах;

4.5.3. Улсын байцаагчийн бүрэн эрхээ хэрэгжүүлэх нөхцөл, бололцоогоор хангах;

4.5.4. Улсын байцаагчдын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;

4.5.5. Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил нь гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг агуулсан гэх үндэслэлтэй бол шалгалтын тайлан, дүгнэлт, холбогдох баримтыг холбогдох хуулийн байгууллагад шилжүүлэх эсэхийг шийдвэрлэх.

4.6. Улсын байцаагч нь бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны дүрмийн 2.2.4-д заасан баталгаагаар хангагдана.

Тав. Улсын байцаагчаас шалгалтын мөрөөр авах арга хэмжээ, ногдуулах захиргааны шийтгэл.

5.1. Улсын байцаагч хяналт, шалгалтын дүнгийн талаар шалгалт дууссанаас хойш ажлын 7 хоногийн дотор тайлан, дүгнэлт бичиж харьяалагдах газрын улсын ахлах байцаагчид танилцуулна.

5.2. Улсын байцаагч хийсэн шалгалтын тайландаа Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 26.1 болон шалгалтын удирдамжид заасан зүйлийг тусгаж, 2 хувь үйлдэж гарын үсэг, тэмдэг дарж баталгаажуулан, шалгуулсан байгууллагын эрх бүхий албан тушаалтанд танилцуулж, мөн адил баталгаажуулж хувийг өгнө.

5.3. Тухайн хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан шалгалтын тайланд гарын үсэг зурахаас татгалзсан, эсхүл татгалзсан шалтгааны талаар бичгээр тайлбар өгөхгүй байх нь шалгалтын тайланг хүчин төгөлдөр бус гэж үзэх үндэслэл болохгүй.

5.4. Шалгуулагч захиргааны зөрчил гаргасан нь тогтоогдвол улсын байцаагч шийтгэл ногдуулж, зөрчлийн тухай тэмдэглэл үйлдэн дараах зүйлийг тусгана:

5.4.1. Зөрчил гарсан газар, он, сар, өдөр, цаг, зөрчил гаргасан иргэн, хуулийн этгээдийн нэр, хаяг, эрхэлсэн ажил, албан тушаал;

5.4.2. Зөрчлийн байдал, товч утга, захиргааны хариуцлага хүлээлгэх үндэслэл болсон хууль тогтоомжийн холбогдох заалт;

5.4.3. Хохирогчийн нэр, хаяг, учруулсан хохирол, түүний төрөл, хэмжээ,

5.4.4. Зөрчил гаргасан этгээдийн тайлбар, зөрчлийг хянан шийдвэрлэхэд зайлшгүй шаардлагатай бусад мэдээлэл;

5.4.5. Ногдуулсан шийтгэлийн хэмжээ, биелүүлэх хугацаа, түүний эрх зүйн үндэслэл;

5.5. Зөрчлийн тухай тэмдэглэлд улсын байцаагч, тухайн хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулна.

5.6. Тухайн этгээд зөрчлийн тухай тэмдэглэлд гарын үсэг зурахаас татгалзсан тохиолдолд үндэслэл, шалтгааны талаар тайлбар авч хавсаргана.

5.7. Зөрчил гаргасан этгээд гарын үсэг зурахаас татгалзсан нь захиргааны хариуцлага хүлээхгүй байх, захиргааны шийтгэл биелүүлэхийг хойшлуулах үндэслэл болохгүй.

5.8. Улсын байцаагч хяналт шалгалтын ажлын үр дүнд илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулахаар албан шаардлага өгч болох бөгөөд түүнд дараах зүйлийг тусгана:

5.8.1. Зөрчил гарсан он, сар, өдөр, цаг, холбогдох этгээдийн нэр, хаяг;

5.8.2. Илрүүлсэн зөрчлийн товч утга, зөрчсөн хууль, журмын заалт;

5.8.3. Харилцагч, хөрөнгө оруулагчдад учруулсан хохирол, түүний хэмжээ;

5.8.4. Хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, учруулсан хохирлыг барагдуулахаар өгсөн үүрэг даалгавар;

5.8.5. Өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж, хариу мэдэгдэхийг заасан хугацаа;

5.8.6. Үүрэг, даалгаврыг тогтоосон хугацаанд биелүүлээгүй тохиолдолд авах арга хэмжээ.

5.9. Улсын байцаагч зөрчлийн тухай тэмдэглэл, албан шаардлагын хуудас дээр гарын үсэг зуран, тэмдэг дарж баталгаажуулна.

5.10. Улсын байцаагч зөрчлийн тухай тэмдэглэлээ үндэслэн захиргааны шийтгэл ногдуулахдаа шийтгэврийн хуудас хэрэглэх бөгөөд түүнд шийтгэл ногдуулсан он, сар, өдөр, зөрчил гаргагчийн нэр, хаяг, албан тушаал, гаргасан зөрчлийн товч утга, шийтгэл ногдуулсан улсын байцаагчийн нэр, шийтгэлийн эрх зүйн үндэслэл, хэмжээ, төлөх дансны дугаар, барагдуулах хугацааг тодорхой заана.

5.11. Шийтгэврийн хуудсанд улсын байцаагч гарын үсэг зуран, тэмдэг дарж, зөрчил гаргасан этгээдээр гарын үсэг зуруулж хувийг түүнд хүлээлгэн өгнө.

5.12. Улсын байцаагчаас өгсөн албан шаардлага, зөрчлийн тухай тэмдэглэлийн бүртгэлийг Хорооны Эрх зүйн хэлтэс нэгтгэн хөтөлж дугаарлан, шийтгэврийн хуудсыг нэгтгэж, прокурорын байгууллагаар хянуулж, бүртгэнэ.

5.13. Улсын байцаагч шийтгэврийн мөнгийг зөрчил гаргасан этгээдээр 10 хоногийн дотор зохих дансанд тушаалгаж, шийтгэврийн хуудсыг баримтын хамт буцааж авна.

5.14. Захиргааны шийтгэл хүлээсэн этгээд түүнийг тогтоосон хугацаанд биелүүлээгүй бол шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн журмаар барагдуулах ажлыг тухайн шийтгэлийг ногдуулсан улсын байцаагч хариуцах бөгөөд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад төлөх төлбөрийг шийтгэл хүлээсэн этгээдээс гаргуулна.

Зургаа. Улсын байцаагчийн үйл ажиллагаанд хориглох зүйл.

6.1. Улсын байцаагчийн үйл ажиллагаанд Төрийн албаны тухай хуулийн 15 дугаар зүйл, Авилгатай тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлд зааснаас гадна дараах зүйлийг хориглоно:

6.1.1. Хяналт тавих, шалгалт хийх явцад олж авсан байгууллага, иргэний нууц баримт бичиг, түүнтэй холбоотой мэдээллийг бусдад дамжуулах, хувийн зорилгоор ашиглах, тараах;

6.1.2. Хувийн ашиг сонирхлын үүднээс хяналт, шалгалтын дүнг гуйвуулах;

6.1.3. Шалгалт дуусаагүй, нэгдсэн дүгнэлт гараагүй байхад урьдчилан дүгнэлт гаргах, мэдээ, мэдээлэл тараах, түүнийгээ батлах зорилгоор шалгалтыг үргэлжлүүлэн хийх, хууль бус үйлдлийг нуун дарагдуулах;

6.1.4. Шалгалт хийх, тайлан, дүгнэлт бичих, албан шаардлага өгөх, захиргааны шийтгэл ногдуулах явцдаа бусдын нөлөөнд автах, авилгалд өртөх;

6.1.5. Бичигдээгүй шалгалтын тайлан, дүгнэлт, танилцуулга, албан шаардлага, зөрчлийн тухай тэмдэглэлд урьдчилан гарын үсэг зурах, тэмдэг дарах, дугаар өгөх, улсын байцаагчийн гарын үсгийг дуурайлган зурах, тэмдгийг ашиглах;

6.1.6. Улсын байцаагчийн үнэмлэх, тэмдэг, албан шаардлагын болон зөрчлийн тухай тэмдэглэлийн хэвлэмэл хуудас, шийтгэврийн хуудсыг хууль бус үйл ажиллагаанд ашиглах, хуурамчаар үйлдэх, бусдад шилжүүлэх, ашиглах боломж олгох;

6.1.7. Шалгагдаж буй байгууллага, иргэдээс зээл авах, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө, ажил үйлчилгээг зах зээлийн үнийн жишгээс доогуур үнээр худалдан авах, түрээслэх, үйлчлүүлэх;

6.1.8. Зохицуулалтын хүрээний байгууллагуудын төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, хяналтын зөвлөл, түүнтэй адилтгах бүтцийн гишүүн байх, хуульд заагаагүй үүрэг хүлээх;

6.1.9. Улсын байцаагч бусад улсын байцаагч нартаа хийж байгаа шалгалттай нь холбогдуулан ямар нэгэн хүсэлт тавих, дарамт шахалт үзүүлэх, хөндлөнгөөс нь нөлөөлж тайлан, дүгнэлт гаргуулах, албан шаардлага, зөрчлийн тухай тэмдэглэл үйлдүүлэх.

Долоо. Улсын байцаагчид хүлээлгэх хариуцлага.

7.1. Улсын ерөнхий байцаагч дараах тохиолдолд Төрийн албаны тухай хууль, Хорооны ажилтны ёс зүйн дүрэмд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ:

7.1.1. Гэм буруутай тухай шүүхийн шийтгэх тогтоол гарсан;

7.1.2. Энэ дүрмийн 4-д заасан эрхийг хэтрүүлэн ашиглаж, үүргээ биелүүлээгүй, 6-д заасан зүйлийг үйлдсэн нь нотлогдсон;

7.1.3. Төрийн албаны тухай хууль, Хорооны ажилтны ёс зүйн дүрэм зөрчсөн нь тогтоогдсон.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО